



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/386

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11/34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Сонгинохайрхан дүүрэгт 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар (Г.Энхтайван)-т шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг үүрэг болгосугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 190,000,000 (нэг зуун ерэн сая) төгрөгийг "Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021-2022 он дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын 139 дэх заалтад заасан "Бусад" зардлаас холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэлээр нь хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Мишээлт)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг "Улаанбаатар лифт" ОНӨТҮГ (Д.Ган-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЬЯАБАЗАР

111020001836

Нийслэлийн Засаг даргын 2022 оны
03 сарын 14-ны өдрийн
... захиралжийн
хэвсрэлт

НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

(сая төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн
1	Цахилгаан шат шинэчлэх ажил (СХД, 29 дүгээр хороо)	2022	190.0	190.0 ✓
	ДҮН		190.0	190.0